



## АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ АЙМГИЙН ДУНД БОЛОН  
БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДУУЛАХ  
ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ  
ӨГӨХ

АУДИТЫН КОД: АРА-2024/03-01-НА-НА

Архангай аймаг 2024 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх  
аудитор Т.Байгалмаа  
Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn  
Ахлах аудитор Н.Алтантуяа  
Утас: 99338611 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn  
Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ  
Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn  
Аудитор А.Пүрэвцэцэг  
Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn  
Аудитор Б.Азонтунгалаг  
Утас: 92091017 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах  
хаягаар авна уу.



<p><b>Тайлан бэлтгэсэн:</b> Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ <b>Товчилсон үгийн тайлбар</b></li> <li>➤ <b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b></li> </ul>
<p><b>Тэргүүлэх аудитор</b> <b>Т.Байгалмаа</b></p> <p><b>Аудитын менежер</b> <b>Д.Нэргүйбаатар</b></p> <p><b>Ахлах аудитор</b> <b>Н.Алтантуяа</b> <b>Г.Цог-Эрдэнэ</b> <b>Аудитор</b> <b>Б.Азатунгалаг</b> <b>А.Пүрэвцэцэг</b></p> <p>2024 оны 11 дүгээр сар Уг тайланг <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу</p> <p>Хаяг: Архангай аймаг Эрдэнэбулган сум 2-р баг: Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар</p>	<p><b>БҮЛЭГ 1</b> ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ АЙМГИЙН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН ЭСЭХЭД ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА</p> <p><b>БҮЛЭГ 2</b> ТӨСВИЙН ОРЛОГЫН САНГИЙН ЯАМНААС 33.0 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ ХЯНАСАН БАЙНА</p> <p><b>БҮЛЭГ 3</b> ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ 2024 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 27.5 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА</p> <p><b>БҮЛЭГ 4</b> ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАХ-НИЙ 44.4 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА</p> <p><b>ДҮГНЭЛТ</b> <b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ</b> <b>ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ</b></p> <p><b>Хүснэгтийн товьёг</b> Хүснэгт №1 Аймгийн 2024 оны нийт орлогын ба тусламжийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл Хүснэгт №2 Орон нутгийн 2025 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл Хүснэгт №3 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, зарцуулах төсөв Хүснэгт №4 Орон нутгийн орлогын харьцуулсан судалгаа Хүснэгт №5 ОНӨААТҮГ-ын орлогын зарлагын харьцуулсан судалгаа Хүснэгт №6 ОНӨААТҮГ-ын орлогын судалгаа Хүснэгт №7 Төсвийн санал ба батлагдсан суурь зарлагын дүн Хүснэгт №8 Төсвийн санал ба хянасан төслийн харьцуулалт Хүснэгт №9 Төсөвт байгууллагуудад хуваарилсан зардал Хүснэгт №10 Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл Хүснэгт №11 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний жагсаалт Хүснэгт №12 Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал Хүснэгт №13 Төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх мэдээлэл Хүснэгт №14 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний дэлгэрэнгүй жагсаалт Хүснэгт №15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт Дүрслэлийн товьёг 1 Санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн шилжүүлэг (сүүлийн 3 жилээр) Дүрслэлийн товьёг 2 Аймгийн 2024 оны төсвийн орлогыг өмнөх онуудтай харьцуулалт Дүрслэлийн товьёг 3 Нийт зардлын дүнд эзлэх хувь Дүрслэлийн товьёг 4 ХО-ын ангилал</p>



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АДБОУС</b>	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
<b>МУ</b>	<i>Монгол Улс</i>
<b>УИХ</b>	<i>Улсын Их Хурал</i>
<b>ЗГ</b>	<i>Засгийн газар</i>
<b>ИТХ</b>	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
<b>ТЕЗ</b>	<i>Төсвийн ерөнхийлөн захирагч</i>
<b>ЗДТГ</b>	<i>Засаг даргын тамгын газар</i>
<b>СТСХ</b>	<i>Санхүү төрийн сангийн хэлтэс</i>
<b>ХОХБТХ</b>	<i>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс</i>
<b>БОХГ</b>	<i>Байгаль орчныг хамгаалах газар</i>
<b>ОНӨГ</b>	<i>Орон нутгийн өмчийн газар</i>
<b>СХДАА</b>	<i>Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба</i>
<b>ГХБХБГ</b>	<i>Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар</i>
<b>ХТҮГ</b>	<i>Хот тохижилт үйлчилгээний газар</i>
<b>ХААГ</b>	<i>Худалдан авах ажиллагааны газар</i>
<b>ОНХС</b>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<b>ОНТХО</b>	<i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт</i>
<b>ТАХ</b>	<i>Төсөл арга хэмжээ</i>
<b>ХХОАТ</b>	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>
<b>ХБГ</b>	<i>Хүлээгдэж буй гүйцэтгэл</i>
<b>ТЭЗҮ</b>	<i>Техник эдийн засгийн үндэслэл</i>
<b>ОНӨААТҮГ</b>	<i>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар</i>
<b>ГХУСЗ</b>	<i>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал</i>
<b>ЗДНХ</b>	<i>Засаг даргын нөөц хөрөнгө</i>
<b>ЭХЯ</b>	<i>Эрчим хүчний яам</i>
<b>ЭМТ</b>	<i>Эрүүл мэндийн төв</i>



## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" 2023 оны 162 дугаар тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

### Аудитын зорилго

Орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын ерөнхий зарчим, зорилго, хамрах хүрээ, арга хандлага, шалгах зүйл, шалгуур үзүүлэлтийг стандартад нийцсэн, хараат бус байдлыг хангасан үр нөлөө бүхий дүгнэлт, зөвлөмж гаргахыг зорьж ажиллалаа. Архангай аймгийн 2025 оны орон төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх;
- Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлогын саналыг хууль тогтоомжид заасны дагуу иж бүрэн, бодитой тооцож төлөвлөсөн эсэх;
- Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд зарлагын саналыг хууль тогтоомжид заасны дагуу иж бүрэн, бодитой тооцож төлөвлөсөн эсэх;
- Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байхаар төлөвлөсөн эсэх;

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1: 2020 Төрийн аудитын тулгуур зарчим, MNS 6817 -5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал", А/71 дүгээр тушаалаар баталсан "Нийцлийн аудитын заавар, аргачлал" 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан "Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал"-ыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалыг гол шалгуур болголоо.

### Аудитын хамарсан хүрээ

Аудитын явцад Архангай аймгийн 2024 оны төсөв, төсвийн тодотгол, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, аймгийн Засаг даргаас Сангийн яаманд хүргүүлсэн 2025 оны жилийн төсвийн санал, Сангийн яамнаас хянаж ирүүлсэн тооцоо, холбогдох мэдээлэл, аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ, БОХГ, Татварын хэлтэс, сумдын татварын байцаагч болон



төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, орлого, зардал, төсөвтэй холбоотой тайлан, мэдээ, судалгаа, өмнөх онуудын аудитын тайлан, аймгийн ИТХ-д хүргүүлсэн санал дүгнэлт зэрэгт үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлон дүн шинжилгээ хийв.

### **Талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Аймгийн Засаг дарга нь жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга,... тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх” гэж заасан.

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн Орон нутгийн төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын 7.4-т “Аймаг, нийслэлийн аудитор жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### **Аудитын бүрэлдэхүүн**

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Алтантуяа, Г.Цог-Эрдэнэ, аудитор Б.Азантунгалаг, А.Пүрэвцэцэг нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

### **Хүндрэл бэрхшээл**

Аймгийн Засаг дарга нь орон нутгийн 2025 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1605 дугаар албан бичгээр холбогдох материалыг ирүүлсэн. Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг 5 хоногийн хугацаанд гүйцэтгэдэг нь мэдээллийг иж бүрэн шинжлэх, дүгнэлт гаргахад хязгаарлагдмал нөхцөл байдал үүсдэг.

Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн төсвийн төслийг иж бүрэн биш, шаардлагатай нэмэлт мэдээлэл, судалгаа, тооцоо, холбогдох баримт бичиг, нотлох баримтаар дэмжигдээгүй нь аудитын нягтлах ажилд нотлох баримтыг дахин гаргуулж авах, хугацаа алдах зэрэг хүндрэлүүд гарч байлаа.

## **ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Аймгийн төсвийн орлого 2024 оны 10 дугаар сарын байдлаар 25,360.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 9,007.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, орон нутгийн төсвийн зарлага 56,533.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нь өмнөх оны мөн үеэс 16,438.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй үзүүлэлттэй байна. /аймгийн нийгэм эдийн засгийн байдал статистик эмхэтгэл -2024.10 сар /

Аймгийн төсвийн нийт орлого ба тусламжийн орлогын төлөвлөгөө 2024 оны 10 дугаар сарын байдлаар 47,807.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 57,138.5 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 9,330.6 сая төгрөгөөр буюу 20 хувиар давж биелжээ.



Хүснэгт1. Аймгийн 2024 оны нийт орлого ба тусламжийн орлого төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хэрэгжилтийн хувь
1	Татварын орлого	15,524.7	22,539.8	7,015.1	145%
2	Татварын бус орлого	1,990.6	2,770.9	780.2	139%
3	Хөрөнгийн орлого	26.0	49.7	23.7	191%
4	Бусад орлого /Санхүүгийн дэмжлэг/	30,266.7	31,778.1	1,511.5	191%
<b>Нийт орлого</b>		<b>47,807.91</b>	<b>57,138.5</b>	<b>9,330.6</b>	<b>120%</b>

Орон нутгийн 2025 оны төсвийн төслийн тооцооллыг Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн удирдамжийн дагуу бэлтгэн онлайнд суурилсан FISCAL-B системд зардлын эдийн засгийн ангилал, зориулалт, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрээр оруулж, судалгааны хамт Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлжээ. Төсвийн саналд суурь орлогыг 19,751.0 сая төгрөг, зарлагыг 77,078.5 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.

Монгол Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 29-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн тухай хуулиар Архангай аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 52,186.4 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 14,505.7 сая төгрөгөөр тусгасныг хэлэлцэж баталсан байна.

Санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг өмнөх онуудтай харьцуулан авч үзвэл:

Дүрслэл № 1 Санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн шилжүүлэг (сүүлийн 3 жилээр)



Санхүүгийн дэмжлэгийг 2023 онтой харьцуулахад 3 дахин, 2024 онтой харьцуулахад 1.4 дахин өссөн байна. Харин ОНХС-ийн шилжүүлгийг 2023 онтой харьцуулахад 1.7 дахин, 2024 онтой харьцуулахад 1.2 дахин өссөн нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт, төрийн албан хаагчдын цалингийн өсөлттэй холбоотой байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд нийт орлого 94,767.2 сая төгрөг үүнээс 27,024.1 сая төгрөг нь орон нутгийн төсвийн орлого, 11.0 сая төгрөг нь ТЕЗ түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого, 52,186.4 сая төгрөг нь улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, 14,505.7 сая төгрөг нь ОНХС-ийн орлогын шилжүүлэг, 60.0 сая төгрөг нь цэргийн дүйцүүлэх албаны, 80.0 сая төгрөг нь мал хамгаалах сангийн орлого, 900.0 сая төгрөг нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцсон төсвийн урьд оны үлдэгдэл орлогууд төсөвлөгдсөн байна.

Төсвийн төсөлд 2025 оны төсвийн жилд зарцуулах нийт хэмжээг 94,767.2 сая төгрөгийн зардлаас 27,649.3 сая төгрөг нь сумын удирдлагын салбарын зардал, 25,245.9 сая төгрөг нь аймгийн удирдлагын салбарын зардал, 151.6 сая төгрөг нь халамжийн сангийн төсөв, 15,181.4 сая төгрөг нь ОНХСан, 21,196.5 сая төгрөг нь орон нутгийн байгууллагын барилга ашиглалтын зардал, 5,262.5 сая төгрөг нь аймгийн төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын зардал, 80.0 сая төгрөг нь мал хамгаалах санд зарцуулахаар төлөвлөжээ.



Аймгийн ИТХ-аар батлагдах 2025 оны орон нутгийн төсвийн тэнцэл 94,767.2 сая төгрөг байна.

Хүснэгт 2. Орон нутгийн 2025 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл

<b>Орон нутгийн нийт орлого, санхүүгийн дэмжлэгийн дүн</b>	<b>94,767.2</b>
Орон нутгийн орлого	27,024.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого	11.0
Санхүүгийн дэмжлэг	52,186.4
Урьд оны төсвийн үлдэгдлээс /мал хамгаалах сан, цэргийн дүйцүүлэх алба/	140.0
ОНХС-ийн шилжүүлэг	14,505.7
Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдэл	900.0
<b>Орон нутгийн зарлагын дүн</b>	<b>94,767.2</b>
Сумын удирдлагын салбарын дүн	27,649.3
Аймгийн удирдлагын салбарын дүн	25,245.9
Халамжийн сангийн дүн	151.6
ОНХСанд зарцуулах	15,181.4
Орон нутгийн байгууллагын барилга ашиглалтын зардал / Боловсрол, соёл, эрүүл мэнд /	21,196.5
Их засвар	5,262.5
Мал хамгаалах сан	80.0

Нийт орлогын 28.5 хувь орон нутгийн төсвийн орлого, 54.0 хувь санхүүгийн дэмжлэг, 15.3 хувь нь ОНХС-ийн орлогын шилжүүлэг, урд оны үлдэгдлээс 1.1 хувь санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн төсөлд өгөх орон нутгийн төсвийн орлого, зардал, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг дараах бүлгүүдэд тусган танилцуулж байна.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ АЙМГИЙН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН ЭСЭХЭД ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

### 1.1 Аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж байна

Монгол Улсын засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тогтоолоор Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн хязгаарыг 78,608.4 сая төгрөгөөр баталсныг Сангийн Яам 78,537.8 сая төгрөгөөр хянажээ.

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны төсвийн тухай хуулийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсны дагуу Сангийн яамнаас 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 03/9591 тоот албан бичгээр орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч ажиллах чиглэл ирүүлсэн байна.

2025 онд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр нийт 19 хөтөлбөрт 94,767.2 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байна.



## Хүснэгт 3. ТЭЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, зарцуулах төсөв

(сая төгрөг)

№	Хөтөлбөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	6,242.0
2	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	42,088.0
3	70417	Мэргэжлийн хяналт	621.9
4	70418	Худалдан авах ажиллагаа	399.9
5	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	546.7
6	70501	Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг	15,181.4
7	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,935.4
8	71403	Ойжуулалт	709.8
9	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,795.4
10	71502	Хот байгуулалт, тохижилт	1,923.5
11	71601	Нийгмийн эрүүл мэнд	3,257.6
	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	
12	71701	Биеийн тамир спорт	1,833.0
13	71702	Соёл урлаг	4,620.5
14	71801	Сургуулийн өмнөх боловсрол	3,390.3
15	71802	Ерөнхий боловсрол	9,596.8
16	71804	Мэргэжлийн боловсрол	331.3
17	71902	Нийгмийн халамж	151.6
18	72208	Ахмад настны хөгжил хамгаалал	142.1
<b>Нийт төсөв</b>			<b>94,767.2</b>

Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12- ны өдрийн 05 тоот тогтоолоор “Архангай аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-г баталсан байна. Энэ нь Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Алсын хараа-2050, монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэлтэй уялдсан байна.

2024 оны 10 дугаар сард аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулагдаж, сонгуулийн үр дүнгээр аймгийн засаг дарга 11 дүгээр сард томилогдсонтой холбоотой Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж байна.

### 1.2. Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг хуульд заасан иж бүрдлийн дагуу бэлтгээгүй байна

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1<sup>1</sup>, 67 дугаар зүйлийн 67.2<sup>2</sup>-д заасан төсвийн төслийн танилцуулга мэдээллийг хуульд заасан дарааллын дагуу, иж бүрэн бэлтгээгүй байна. Үүнд: Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, 31.1.6-д “худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх”, 31.4.6-д “төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын

<sup>1</sup> Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:

<sup>2</sup> 67.2 Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:



тооцоо”, 32.2.10-д “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ”, 67.2.1-д “орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө” зэргийг ирүүлээгүй.

Энэ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг зөрчиж байна.

Аудитаас Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 67 дугаар зүйлийн 67.2, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасан шаардлагын дагуу орон нутгийн төсвийн төслийг иж бүрэн боловсруулан ирүүлж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ:ТӨСВИЙН ОРЛОГЫГ САНГИЙН ЯАМНААС 33.0 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ ХЯНАСАН БАЙНА**

### *2.1. Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.2 дахь заалтын дагуу хуваарилаагүй байна*

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд Эрдэнэбулган сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 3,519.1 сая төгрөгөөр тусгажээ. Эрдэнэбулган сумын орон нутгийн төсвийн орлого 11,997.4 сая төгрөг, суурь зарлага 8,478.2 сая төгрөг зөрүү буюу үндсэн тэнцлийн ашиг 3,519.1 сая төгрөгийг сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогоор тооцсон нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т “*Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараах байдлаар төвлөрүүлнэ*”, 56.2.2-т “*Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн ... 70 хувийг ...тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### *2.2. Орон нутгийн төсвийн орлогыг Сангийн яамнаас 33.0 хувиар нэмэгдүүлж хянасан байна*

Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг 27,035.1 сая төгрөгөөр төлөвлөсний 92.4 хувь буюу 24,984.8 сая төгрөг татварын орлого, 7.6 хувь буюу 2,050.3 сая төгрөг татварын бус орлого байна.

Аймгийн Засаг даргаас төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төслийг боловсруулах удирдамж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам зааврын хүрээнд орон нутгийн орлогын төсвийн төслийг боловсруулахдаа сумдаас ирүүлсэн төсвийн төсөл, мэргэжлийн байгууллагууд, газар хэлтсүүдээс ирүүлсэн холбогдох тооцоо судалгааг нэгтгэж, орон нутгийн төсвийн суурь орлогыг 19,751.0 сая төгрөгөөр боловсруулан саналыг Сангийн Яаманд хүргүүлжээ.



## Хүснэгт 4. Орон нутгийн орлогын харьцуулсан судалгаа (сая төгрөг)

ДД	Үзүүлэлтийн нэр	Орон нутгаас хүргүүлсэн 2025 оны орлогын төсвийн төсөл		Сангийн Яам хянасан		Нийт орлогын зөрүү	Хувь	Аймгийн ИТХ-аар батлагдах
		Суурь орлого	Нийт орлого	Суурь орлого	Нийт орлого			
1	АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО БҮГД	19,751.0	20,311.0	26,351.4	27,027.1	6,716.1	133%	27,035.1
1.1.	ТАТВАРЫН ОРЛОГО	18,141.8	18,701.8	24,309.0	24,984.8	6,283.0	134%	24,984.8
1.1.1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татвар	13,810.0	13,810.0	17,000.0	17,000.0	3,190.0	123%	17,000.0
1.1.2	Үйл ажиллагааны орлого	600.0	600.0	650.0	650.0	50.0	108%	650.0
1.1.3	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	1,621.5	1,621.5	3,420.0	3,420.0	1,798.5	211%	3,420.0
1.1.4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	300.0	300.0	327.0	327.0	27.0	109%	327.0
1.1.5	Шууд бус орлого	15.3	15.3	20.0	20.0	4.7	131%	20.0
1.1.6	ХХОАТ буцаалт	(1,472.0)	(1,472.0)	(1,472.0)	(1,472.0)	-	100%	(1,472.0)
1.1.7	Бичил худалдаа, үйлчилгээ эрхэлсний орлого	6.5	9.7	6.5	9.7	-	100%	9.7
1.1.8	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	1,100.0	1,100.0	1,700.0	1,700.0	600.0	155%	1,700.0
1.1.9	Үл хөдлөх хөрөнгийн татвар	357.4	610.5	407.0	695.0	84.5	114%	695.0
1.1.10	Бууны албан татвар	77.8	77.8	82.0	82.0	4.2	105%	82.0
1.1.11	Авто тээвэр өөр явагч хэрэгслийн албан татвар	399.8	523.9	639.0	837.0	313.1	160%	837.0
1.1.12	Улсын тэмдэгтийн хураамж	231.1	255.1	243.0	268.0	12.9	105%	268.0
1.1.13	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12.6	12.6	12.6	12.6	-	100%	12.6
1.1.14	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	572.7	572.7	572.7	572.7	-	100%	572.7
1.1.15	Газрын төлбөр	204.9	317.9	215.0	334.0	16.1	105%	334.0
1.1.16	Газрын дуудлага худалдааны орлого	14.0	14.0	14.0	14.0	-	100%	14.0
1.1.17	Ойн нөөц ашигласны төлбөр	222.0	222.0	225.0	225.0	3.0	101%	225.0
1.1.18	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	18.4	18.4	180.0	180.0	161.6	979%	180.0
1.1.19	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	47.2	89.8	47.2	89.8	-	100%	89.8
1.1.20	Байгалийн ургамал ашигласны төлбөр	2.7	2.7	20.0	20.0	17.3	753%	20.0
1.1.21	Малын тоо толгойн албан татвар	-	-	-	-	-	-	-
1.2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,609.2	1,609.2	2,042.4	2,042.4	433.2	127%	2,050.4
1.2.1	Хүүгийн орлого	-	-	444.8	444.8	444.8	-	444.8
1.2.2	Торгуулийн орлого	1,196.1	1,196.1	1,200.0	1,200.0	3.9	100%	1,200.0
1.2.3	Түрээсийн орлого	27.6	27.6	27.6	27.6	-	100%	27.6
1.2.4	Нэр заагдаагүй бусад орлого	352.0	352.0	352.0	352.0	-	100%	352.0
1.2.5	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	15.0	15.0	15.0	15.0	-	100%	15.0
1.2.6	Төсөвт газрын өөрийн орлого	18.5	18.5	3.0	3.0	(15.5)	16%	11.0

Эх сурвалж: Аймгийн СТСХ



Сангийн яамнаас аймаг, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс суурь орлогыг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан нийт дүнгээр **33.0** хувь буюу **6,716.1** сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна. Өндөр дүнгээр нэмэгдүүлсэн зарим нэр төрлийн орлогыг авч үзвэл:

- ✚ Цалин хөлсний орлогын албан татварыг 2025 онд төрийн албан хаагчдын үндсэн цалинг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 23 хувь буюу **3,190.0** сая төгрөг,
- ✚ Хадгаламжийн хүүгийн орлогын татварыг 111 хувиар буюу **1,798.5** сая төгрөг,
- ✚ Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 55 хувь буюу **600.0** сая төгрөг,
- ✚ Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 60 хувь буюу 313.1 сая төгрөг
- ✚ Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 879 хувь буюу **161.6** сая төгрөг
- ✚ Байгалийн ургамал ашигласны төлбөр 653 хувь буюу **17.3** сая төгрөг
- ✚ Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлттэй холбоотой хүүгийн орлогыг **444.8** сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна.

Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн орлогод Сангийн Яамнаас хянасан суурь орлого 26,351.4 сая төгрөг, нийт болон суурь орлогын зөрүүгээр 675.7 сая төгрөг нэмэгдэж, аймгийн ЗДТГ-ын өөрийн орлогыг 8.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн аймгийн төсвийн орлогыг нийт **27,035.1** сая төгрөгөөр батлуулахаар төлөвлөсөн байна.

Дүрслэл 2 Аймгийн 2025 оны төсвийн орлогыг өмнөх онуудтай харьцуулан авч үзвэл:



Нийт орлогод татварын орлогын эзлэх хэмжээ 2021 онд 91.8 хувь, 2022 онд 89.3 хувь, 2023 онд 82.3 хувь, 2024 онд 89.9 хувь, 2025 онд 92.4 хувийг эзэлж байсан байна. Аймгийн төсвийн орлогын хэмжээг Сангийн яамнаас жил бүр нэмэгдүүлэн хянаж байгаа бөгөөд 2025 оны орлогыг өмнөх онтой харьцуулахад 5,359.1 сая төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн байна.

Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.10 “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ”-г Орон нутгийн төсвийн төсөлд тооцож тусгана гэж заасан.

Аудитаас “Ар ус ундарга” ХК ОНӨҮГ болон “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ууд нь 2021-2024 оны тайланд судалгаа хийж үзэхэд эдгээр хуулийн этгээдүүд нь алдагдалтай ажиллаж, ногдол ашиг төвлөрүүлдэггүй нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, ашигтай ажиллах



дүрэм, журмаа зөрчиж байгаа байдал ажиглагддаг. Иймд эдгээр ОНӨААТҮГ-уудыг үр ашигтай ажиллах бизнес төлөвлөгөөг батлах, төсөвт дарамт үүсгэхээс сэргийлэх, дамжуулан зээлийн өрийг барагдуулахад тодорхой хэмжээний оролцоо бий болгоход анхаарч улмаар ногдол ашгийг төсөвт төлөвлөж хэвших нь зүйтэй.

Хүснэгт 5. ОНӨААТҮГ-ын орлого зарлагын харьцуулсан судалгаа (сая төгрөг)

Д/д	ОНӨААТҮГ	Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 оны хагас жилийн байдлаар
1	"Ар Ус Ундарга" ХК	Орлого	1,325.2	1,226.9	1,572.4	867.7
		Зарлага	1,397.1	1,537.4	1,727.3	877.2
		Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/	(71.9)	(310.5)	(154.9)	(9.5)
2	"Архангайд үйлдвэрлэв" ОНӨААТҮГ	Орлого	153.9	203.8	218.4	124.7
		Зарлага	184.8	476.6	285.1	160.1
		Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/	(30.9)	(272.8)	(66.7)	(35.4)

Түүнчлэн 2022-2023 онуудад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 148.8 сая төгрөгийн Хотонт үүлдрийн 800 толгой хонь, 150.0 сая төгрөгийн 19 толгой монбелиард үүлдрийн үхэр нийт 298.8 сая төгрөгийн 819 толгой мал, 397.4 сая төгрөгийн хөдөө аж ахуйн зориулалт бүхий техник, тоног төхөөрөмж зэргийн ашиглалт, үр ашгийг сайжруулахаар замаар түрээсийн орлого болон орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлого зэргийг нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

Хүснэгт 6. ОНӨААТҮГ-ын түрээсийн орлогын судалгаа (сая төгрөг)

Орлогын нэр төрөл	Орон нутгаас хүргүүлсэн санал	Сангийн хянасан	Яам	ОНӨГ-аас ирүүлсэн санал	Зөрүү
Түрээсийн орлого	27.6		27.6	43.2	15.6
Дуудлага худалдааны орлого	15.0		15.0	40.0	25.0
Нийт дүн	42.6		42.6	83.2	40.6

Эх сурвалж: Аймгийн СТХС, ОНӨГ-ын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны 424 тоот албан бичиг

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ 2024 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 27.5 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

**3.1. Орон нутгийн 2025 оны төслийн төсөлд төсвийн зарлагын саналыг Сангийн яамнаас ирүүлсэн ТЕЗ нарын 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж чиглэлийн дагуу боловсруулсан байна**

Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсөл боловсруулах журам"-ын дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудын 2025 оны төсвийн төслийг холбогдох маягтын дагуу хүлээн авч хянан Сангийн Яамнаас ирүүлсэн ТЕЗ нарын 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж чиглэлийн дагуу нэмэлт тооцооллуудыг хийж, төсвийн урсгал зардлыг төлөвлөжээ.

Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагын саналыг нийт **77,078.7** сая төгрөгөөр төлөвлөн Сангийн Яаманд хянуулахаар хүргүүлснийг **1,459.3** сая төгрөгөөр буюу 1.9 хувиар нэмэгдүүлэн аймгийн төсвийн суурь зарлагыг **78,537.8** сая төгрөгөөр хянасан байна.



Төсвийн санал ба батлагдсан суурь зарлагын дүнг хүснэгтээр харуулбал:


Хүснэгт 7. Төсвийн санал ба батлагдсан суурь зарлагын дүн (сая төгрөг)

Зардлын ангилал	2025 оны төсвийн зарлагын санал	2025 он Сангийн Яам хянасан	Зөрүү	Өсөлт бууралтын хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,078.5	78,537.8	1,459.3	101.9
УРСГАЛ ЗАРДАЛ	71,445.2	73,275.4	1,830.2	102.6
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,074.1	71,465.4	1,391.2	102.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	29,619.5	28,189.9	(1,429.6)	95.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,702.4	3,560.8	(141.7)	96.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,414.8	20,603.1	3,188.3	118.3
Хангамж, бараа материалын зардал	1,737.2	1,680.2	(57.0)	96.7
Нормативт зардал	735.9	717.9	(18.0)	97.6
Эд хогшил, урсгал засварын зардал	3,644.5	4,006.5	362.0	109.9
Томилолт, зочны зардал	819.3	752.3	(67.1)	91.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,720.0	10,273.6	553.5	105.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,680.4	1,681.1	(999.3)	62.7
Хүү	0.0	444.8	444.8	-
ТАТААС	358.1	358.1	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,013.0	1,007.2	(5.8)	99.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,500.0	5,262.4	(1,237.6)	81.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,078.5	78,537.8	1,459.3	101.9
Улсын төсвөөс санхүүжих	77,942.2	78,534.8	592.6	100.8
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3.0	3.0	-	100.0
Бусад эх үүсвэр	-866.6	0.0	866.6	-

Хүснэгтээс харахад цалин, НДШ, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, томилолт, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг болон хөрөнгийн зардлыг 0.6-37.3 хувиар бууруулан хянаж, харин байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, хүү зэрэг зардлыг 5.7–100 хувиар нэмэгдүүлсэн нь Монгол Улсын ЗГ-ын хэрэгжүүлж буй бодлого шийдвэртэй холбоотой байна. Тухайлбал:

- ✚ Засгийн газраас эрчим хүчний салбарын шинэчлэлийг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг ЭХЯ болон эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ирүүлсэн тооцооллын дагуу зардлыг нэмж төлөвлөсөн байна.
- ✚ Цалин хөлсний зардлыг Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, 2023 оны 240 дүгээр тогтоол 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолд нийцүүлэн боловсруулж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувь нэмэгдүүлэхээр тооцож төлөвлөсөн байна.
- ✚ Бүсчилсэн хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт бодлогын хүрээнд хөрөнгийн зардлыг өмнөх оноос нэмэгдүүлж, ЗГ-ын дэд хөтөлбөрүүд болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардал зэргийг төсөвт тусган хянажээ.

Дүрслэл 3. Нийт зардалд эзлэх хувь



Сангийн Яамнаас хянасан төсвийн зарлагыг зардлын эдийн засгийн ангиллаар авч үзвэл: Нийт зардлын 40.4 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 26.2 хувийг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 13.1 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 6.7 хувийг хөрөнгийн зардал, 5.1 хувийг эд хогшил урсгал засварын зардал, 2.1 хувийг хангамж бараа материалын зардал, 6.4 хувийг бусад урсгал зардлууд эзэлж байна.

Сангийн яамны хянасан төсвийн төслийг аймгийн ИТХ-аар батлуулахаар ирүүлсэн төсөлтэй харьцуулахад урьд төсвийн үлдэгдэл 1,048.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Хүснэгт 8. Төсвийн санал ба хянасан төсвийн харьцуулалт (сая төгрөг)

№	Байгууллагын нэр	Орон нутгаас хүргүүлсэн 2025 оны төсвийн санал	Сангийн Яам хянасан 2025 оны дүн	Аймгийн ИТХ-аар батлуулах	Зөрүү /4-3/
	1	2	3	4	5
1	Аймгийн ИТХ	1,382.4	944.8	1,379.3	434.5
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	-	480.0	480.0	-
2	Сумдын ИТХ	4,298.0	4,382.7	4,382.7	-
3	Аймгийн ЗДТГ	13,081.2	11,573.5	6,258.8	(5,314.7)
	Засаг даргын нөөц хөрөнгө	1,000.0	1,000.0	1,215.0	215.0
4	Сумдын ЗДТГ	21,117.2	20,677.4	23,266.6	2,589.2
5	Хот тохижилт үйлчилгээний газар	2,116.0	1,607.3	1,923.5	316.2
6	Ойн анги	758.2	709.8	709.8	-
7	Байгаль орчныг хамгаалах газар	2,073.3	1,550.0	1,795.4	245.4
8	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал		367.9		(367.9)
9	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	629.4	591.8	621.9	30.1
10	Орон нутгийн өмчийн газар	735.0	520.4	546.7	26.3
11	Худалдан авах ажиллагааны газар	431.4	373.6	399.9	26.3
12	Халамжийн сан	151.6	151.6	151.6	-
13	Засаг даргын ерөнхий данс	2,077.5	2,078.2	7,473.6	5,395.4
14	Хотын хүн тээрийн үйлчилгээ	358.1	358.1	358.1	-
15	Орон нутгийн авто замын сан	1,157.6	1,639.3	1,639.3	-
16	Их завсар	6,500.0	5,262.4	5,262.4	-
17	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалт, үйлчилгээ / Боловсрол, соёл, эрүүл мэнд/	17,782.1	21,196.5	21,196.5	-
18	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалт, үйлчилгээ / орон нутгийн удирдлагын салбар /	2,296.1	2,627.8	-	(2,627.8)
19	Дамжуулан зээлийн хүүгийн төлбөр	(866.6)	444.7	444.7	-
20	Мал хамгаалах сан		-	80.0	80.0
	ДҮН	<b>77,078.5</b>	<b>78,537.8</b>	<b>79,585.8</b>	1,048.0

Сангийн Яамнаас хянасан төсвийн зардлыг аймгийн ИТХ-аар батлуулах төсвийн төсөлд

дараах өөрчлөлтүүдийг хийж хуваарилсан байна. Үүнд:

**Хүснэгт 9. Төсөвт байгууллагуудад хуваарилсан байдал ( сая төгрөг)**

Зардлууд	Аймгийн ИТХ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ	БОХГ	СХДАА	ОНӨГ	ХААГ	ХТҮГ	Мал хамгаалах	Засаг даргын ерөнхий	Төрийн өмчийн байр ашиглалт	Өөрийн орлого	Төсвийн урьд оны үлдэгдэл
Хөрөнгийн болон бусад зардалд	400.0	8.0										(8.0)	(400.0)
Орон нутгийн нэмэгдэл	34.5	(2,537.2)		174.6	30.2	26.3	26.3			2,245.3			
Засаг даргын нөөц хөрөнгө		215.0	285.0										(500.0)
Баяр наадмын зардал		(110.0)	110.0										
Тогтмол зардал		414.5	2,153.4	60.0							(2,627.8)		
Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал			357.1	(357.1)									
Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал		(2,850.0)								2,850.0			
Гамшгаас хамгаалах зардал		(300.0)								300.0			
Цэргийн дүйцүүлэх албаны зардал		60.0											(60.0)
Хог хаягдал зайлуулах зардал			(316.2)					316.2					
Мал хамгаалах сангийн зардал									80.0				(80.0)
Нийт нэмэгдсэн, хасагдсан дүн	434.5	(5,099.7)	2,589.3	(122.5)	30.2	26.3	26.3	316.2	80.0	5,395.3	(2,627.8)	(8.0)	(1,040.0)

**3.2 Төсвийн урсгал зардалд үндэслэх тооцоо судалгаагүйгээр 838.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна**

**Цалингийн зардал:**

2024 оны байдлаар аймгийн ТЕЗ-ийн харьяа 46 байгууллагад 649 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 2025 төсвийн төсөлд цалин хөлсний зардлыг Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, 2023 оны 240 дүгээр тогтоолд үндэслэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцож, 28,189.9 сая төгрөгөөр төлөвлөжээ.

**Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалтын зардал:**

Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалтын зардлыг боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын 91 байгууллагад 21,196.5 сая төгрөгийг , орон нутгийн салбарын 21 байгууллагад 2,627.8 сая төгрөг, нийт 23,824.3 сая төгрөгийг 2025 оны төсвийн төсөлд олгохоор тооцож төлөвлөсөн байна.



Эрчим хүчний салбарын шинэчлэлийн бодлогын хүрээнд Сангийн яамнаас аймаг, сумдын эрүүл мэндийн төвүүдийн дулаан алдагдлыг бууруулахаар чиглэж урсгал засварын зардалд 1,199.8 сая төгрөгийг, төвлөрсөн халаалттай сумдын халаалтын үнэ тарифыг аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс шинэчлэн батлахтай холбогдуулан соёлын салбарын тогтмол зардлаас 77.9 сая төгрөгийг, ЕБС-ийн тогтмол зардлаас 131.0 сая төгрөг, нийт 1,408.7 сая төгрөгийг төсөв захирагч бүрээр хуваарилаагүй нөөц байдлаар “Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалтын зардал” гэсэн нэрээр аймгийн ИТХ-аар батлуулахаар төлөвлөж ирүүлсэн.

Аудитын явцад тус зардлыг төсөв захирагч нарт дараах байдлаар хуваарилахаар шийдвэрлэжээ. Үүнд: Их засварын зардалд он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Булган сумын ЭМТ-д 180.0 сая төгрөг, Хангай сумын ЭМТ-д 200.0 сая төгрөг, дулааны алдагдлыг бууруулах шаардлагатай Чулуут сумын ЭМТ-д 294.0 сая төгрөг, Өндөр-Улаан сумын ЭМТ-д 217.0 сая төгрөг, Тариат сумын ЭМТ-д 308.0 сая төгрөгийг хуваарилсан байна.

#### *Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардал:*

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд Засаг даргын ерөнхий дансанд хуваарилсан засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 2,850.0 сая төгрөгийг хуваарилж, 4 зорилтын хүрээнд ерөнхий байдлаар төлөвлөсөн нь төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулах эрсдэлийг бий болгож болзошгүй байх тул зардлыг аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны уялдуулан, эх үүсвэрийг зардлын зүйлээр нарийвчлан тодорхой төлөвлөх нь зүйтэй байна.

#### *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал:*

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлэхээр заасан байдаг.

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хүү торгуулийн орлогын 40 хувь буюу 480.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч хэрэгжүүлэх арга, хэмжээ тодорхойгүй, тооцоо судалгаагүй төсөвлөлтийн шаардлага хангахгүйгээр төлөвлөсөн байна.

Энэ нь “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2.1<sup>3</sup>, 7.1.3<sup>4</sup>, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1<sup>5</sup> дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитаас Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг бодит тооцоо судалгаа, мэдээлэлд үндэслэн төлөвлөж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

<sup>3</sup> Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим болон дараах зарчмуудыг удирдлага болгоно

<sup>4</sup> Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх

<sup>5</sup> 46.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг,



**Хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээ:**

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд Засаг даргын ерөнхий дансанд хотын нийтийн хүн тээвэр үйлчилгээнд 358.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд тухайн санхүүжилтийг олгох, тайлагнах, хяналт тавих нарийвчилсан журамгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, нотлох баримтгүй байна.

Энэ нь “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2.1<sup>6</sup>, 7.1.3<sup>7</sup> дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалаар баталсан “Авто тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм”-ийн 3.1.1-д “Зорчигч тээврийн үйлчилгээг зорчигчийн эрэлт хэрэгцээ, дэд бүтэц, орон сууцны хороолол болон үйлдвэр, үйлчилгээний газруудын байршлаас хамааруулан бусад төрлийн тээврийн үйлчилгээтэй уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгааны арга аргачлалын (зорчигч урсгалын хэмжээ, техник ашиглалтын үзүүлэлт, зардал, үр ашгийн тооцоо г.м) дагуу төлөвлөх ба төлөвлөлтөд олон улсын жишигт нийцсэн программ хангамж, техник технологийг ашиглана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаас хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээний зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, хөнгөлөлттэй үйлчлүүлэх гэрээний нөхцөлийг тодорхой болгох, хяналт хэрэгжүүлэх цахим систем, программ хангамж нэвтрүүлэх, санхүүжилт олгох, хянах, тайлагнах журмыг баталж төсвийг хяналттай үр ашигтай зарцуулах арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАХ-НИЙ 44.4 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА**

**4.1. Нийт хөрөнгө оруулалтын ТАХ-ний 33.3 хувь нь аймгийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна**

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1605 дугаар албан бичгээр ирүүлсэн “аймгийн 2025 оны төсвийн төсөл”-д аймгийн ОНХС, авто замын сан, ОНТХО-ын эх үүсвэрээс санхүүжүүлэх нийт 15,885.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 төсөл, арга хэмжээг 2025 онд 13,455.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Аудитын явцад буюу 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулж аймгийн ОНХС, авто замын сан, ОНТХО-ын эх үүсвэрээс санхүүжүүлэх нийт 15,907.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 ТАХ-г 13,468.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгаж ирүүллээ.

Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл (сая төгрөг)

Ангилал	Хөрөнгө оруулалтын ангилал			Нийт дүн
	Аймгийн ОНХСан	Авто замын сан	Аймгийн ОНТХО	
Барилга	Тоо	4		4

6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

<sup>6</sup> Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим болон дараах зарчмуудыг удирдлага болгоно

<sup>7</sup> “Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх”



байгууламж	Төсөвт өртөг	3,600.0			3,600.0
	Санхүүжих дүн	2,882.2			2,882.2
Их засвар	Тоо	3	1	18	22
	Төсөвт өртөг	1,515.3	1,639.3	6,851.8	10,006.4
	Санхүүжих дүн	1,382.7	1,639.3	5,262.4	8,284.4
Тоног төхөөрөмж	Тоо	3			3
	Төсөвт өртөг	1,000.0			1,000.0
	Санхүүжих дүн	1,000.0			1,000.0
ТЭЗҮ	Тоо	1			1
	Төсөвт өртөг	509.3			509.3
	Санхүүжих дүн	509.3			509.3
Бусад	Тоо	6			6
	Төсөвт өртөг	792.1			792.1
	Санхүүжих дүн	792.1			792.1
Нийт ТАХ	Тоо	17	1	18	36
	Төсөвт өртөг	7,416.7	1,639.3	6,851.8	15,907.8
	Санхүүжих дүн	6,566.3	1,639.3	5,262.4	13,468.0

Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгасан 13,468.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 36 төсөл, арга хэмжээний 11.1 хувь нь барилга байгууламж, 61.1 хувь нь их засварын ажил, 8.3 хувь нь тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлэх, 2.7 хувь нь ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, 16.6 хувь нь бусад хөрөнгө оруулалтын ажлууд байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Хот тохижилт үйлчилгээний газрын хог тээврийн автомашин худалдах авах 250.0 сая төгрөг, Цагдаагийн камержуулалтын тоног төхөөрөмж 500.0 сая төгрөг нийт 750.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээнүүдийг жил бүр төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2020-2024 онуудад аймгийн ОНХС-аас нийт 1,300.2 сая төгрөгийг олгож байжээ.

**Хүснэгт 11. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөж 2020-2024 онд санхүүжилт олгосон байдал**

Төсөл, арга хэмжээний нэр	Огноо	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
Хот тохижилт аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хогны машин худалдах авах	2020	60.0	
	2021	60.0	58.5
	2023	150.0	148.8
	2024	250.0	250.0
	2025	250.0	
Дүн		770.0	457.3
Цагдаагийн камержуулалтын тоног төхөөрөмж	2022	450.0	415.3
	2023	138.3	122.6
	2024	305.0	305.0
	2025	500.0	
Дүн		1,393.3	842.9
НИЙТ ДҮН		2,163.3	1,300.2


Аймгийн ОНХС-ийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дээрх 2 ТАХ-тэй холбоотой дараах зөрчил илэрч байсан. Үүнд:

1. Хот тохижилт, үйлчилгээний газарт 148.8 сая төгрөгөөр худалдан авсан ковш нь ашиглалтын худалдан авсны дараа эвдэрч ашиглалтгүй болсон
2. Аймгийн Цагдаагийн газарт олгосон 122.6 сая төгрөгийн камержуулалтын тоног

төхөөрөмжийг бүрэн ашиглаагүй, камер хянах 8 дэлгэц нь чанарын шаардлага хангаагүй эвдрэл гэмтэл үүссэн зэрэг зөрчил илэрсэнд аудитаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Эдгээр ТАХ-ний үр ашиг, үр дүн хангалтгүй байхад дахин аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх зарчимд нийцэхгүй байх тул анхаарах шаардлагатай.

Дүрслэл 4. ХО-ын ангилал



Аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан нийт хөрөнгө оруулалтын 47.2 хувь буюу 17 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн 6,566.3 сая төгрөгөөр, 2.7 хувь буюу нэг арга хэмжээг авто замын сангийн 1,639.3 сая төгрөгөөр, 50 хувь буюу 18 төсөл, арга хэмжээг аймгийн ОНТХО-ын 5,262.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Дээрх 36 төсөл арга хэмжээний 66.7 хувь буюу давхардсанаар 24 ТАХ нь “Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”-тэй уялджээ.

Хүснэгт 12. Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал

Хөрөнгө оруулалт	Нийт ТАХ-ний тоо	Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал				Бодлогын баримт бичигт тусгагдсан ТАХ /дундаж хувь/
		Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө		
		ТАХ	Хувь	ТАХ	Хувь	
Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	18	18	100.0	8	44.4	72.2
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	17	17	100.0	3	17.6	58.8
Авто замын сан	1	1	100.0	1	100.0	100.0
<b>Нийт</b>	<b>36</b>	<b>36</b>	<b>100.0</b>	<b>12</b>	<b>33.3</b>	<b>66.7</b>

Харин аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 55.5 хувь буюу 10, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 82.3 хувь буюу 14 нийт 24 ТАХ нь аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.17<sup>8</sup>, 6 дугаар зүйлийн 6.10.4<sup>9</sup> дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитаас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 2025 оны хөгжлийн төлөвлөгөө болон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд тусгасан 13,464.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 36 төсөл, арга хэмжээг төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг шалгахад орон нутгийн хөгжлийн сангийн 1,100.0 сая төгрөгийн 5, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын

<sup>8</sup> “төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим” гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг

<sup>9</sup> 6.10.4.орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.



3,655.5 сая төгрөгийн 11 нийт 4,755.5 сая төгрөгийн 16 ТАХ нь ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна. /Тайлангийн хавсралтаас дэлгэрэнгүй байдлаар танилцана уу/

Аудитаас Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-ын дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж, зөрчлийг арилгуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Хүснэгт 12. Төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх мэдээлэл (сая төгрөг)

Ангилал	Нийт ТАХ			Төсөвлөлтийн шаардлага хангаагүй			ТАХ-ний тоонд харьцуулсан хувь
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
Аймгийн ОНХСан	17	7,416.7	6,563.2	5	1,100.0	1,100.0	29.4
Авто замын сан	1	1,639.3	1,639.3	-	-	-	-
Аймгийн ОНТХО	18	6,851.8	5,262.4	11	4,188.2	3,655.5	61.1
<b>Нийт</b>	<b>36</b>	<b>15,907.8</b>	<b>13,464.9</b>	<b>16</b>	<b>5,288.2</b>	<b>4,755.5</b>	<b>44.4</b>

#### 4.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан байна

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн А/789 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах болон дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулжээ.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд 6,563.2 сая төгрөгийн 17 ТАХ-г хэрэгжүүлэх жагсаалтыг боловсруулж, 4 салбарын чиглэлээр 210 хаагчдын дунд хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 20-оос 21-ны өдрүүдэд зохион байгуулж ТАХ-г эрэмбэлсэн байна.

#### 4.3. Төсвийн хөрөнгө оруулалтын саналд хуулиар хориглосон ажлыг тусгаж төлөвлөөгүй байна

Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр төсвийн төсөлд “Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, засвар арчлалт, тохижилт”-ын ажлыг үргэлжлүүлж хийхээр 1,639.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээг тусгасан байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4<sup>10</sup> дэх заалт, МУЗГ-ын 2019 оны 312 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захирах зарцуулах журам”-ын 3.3<sup>11</sup> дахь заалтын дагуу төлөвлөгджээ.

<sup>10</sup> 24.4. Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжид санхүүжүүлнэ.

<sup>11</sup> Гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, замын байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас авто замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжид санхүүжүүлнэ.

**Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 88.9 хувь байна**

Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын үе шат юм.

Аймгийн 2024 оны төсвийн төслийн аудитаар аймгийн ИТХ-д 1, аймгийн Засаг даргад 3 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй гүйцэтгэл 88.9 хувьтай байна.

**Хүснэгт 15. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт**

№	Зөвлөмжийн товч утга	Хариуцах албан тушаалтан	Зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	Аймгийн тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дэх хэсэгт заасан хугацаанд баталж байх	Аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргал	Зөвлөмжийн дагуу аймгийн ИТХ-ын 2024.09.12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг баталжээ.	100
2	Авто замын сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх “Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, засвар арчлалт, тохижилт”-ын ажилд Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулж ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг боловсруулсан байх	Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид	Зөвлөмжийн мөрөөр Цэцэрлэг хотын авто замын засвар, тохижилтын ажлын даалгаварын боловсруулан 2024.04.05-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулжээ.	100
3	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Малчдын өвс, тэжээлийн агуулах, саравч барих” (Хашаат, Өндөр-Улаан, Ихтамир, Булган сум), “Аймгийн хог хаягдлын цэгийг цэгцлэх”, “Өндөр-улаан сумын 420 хүүхдийн хичээлийн байрны засвар”-ын ажлуудад зураг төсөв, ажлын даалгавар боловсруулах, ашиглалтын зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах	Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид	Зөвлөмжийн мөрөөр “Малчдын өвс, тэжээлийн агуулах, саравч барих” (Хашаат, Өндөр-Улаан, Ихтамир, Булган сум), “Аймгийн хог хаягдлын цэгийг цэгцлэх”, “Өндөр-улаан сумын 420 хүүхдийн хичээлийн байрны засвар”-ын ажлуудад 2024.02.15-ны өдөр ажлын даалгаврыг боловсруулан ГХБХБГ-ын даргаар хянуулан аймгийн Засаг даргаар батлуулсан байна.	100



4	Төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д тус тус заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх	Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид	Аймгийн 2025 оны төсвийн төсөлд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 13,464.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 36 ТАХ-нээс 44.4 хувь буюу 4,755.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 16 ТАХ нь ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна.	55.6
<b>Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь дунджаар</b>				88.9



## АУДИТЫН ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлсэд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.**

- ✓ Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 94,767.2 сая төгрөгөөр төлөвлөсний 28.5 хувийг орон нутгийн төсвийн орлогоос, 54.0 хувийг санхүүгийн дэмжлэгээс, 15.3 хувийг ОНХС-ийн орлогын шилжүүлгээс, 1.1 хувийг урьд үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцжээ.
- ✓ Орон нутгийн 2025 оны төсвийн төсөл нь аймгийн дунд хугацааны баримт бичигтэй уялдсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.
- ✓ Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг төсвийн тухай хуульд заасан иж бүрдлийн дагуу бэлтгээгүй байна.
- ✓ Төсвийн орлогын саналыг Сангийн яамнаас 33.0 хувиар нэмэгдүүлж хянасан байна.
- ✓ Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.2 дахь заалтын дагуу хуваарилаагүй байна
- ✓ Төсвийн зарлагын саналыг Сангийн яамнаас ирүүлсэн ТЕЗ нарын 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж чиглэлийн дагуу боловсруулсан байна.
- ✓ Орон нутгийн төсвийн зарлагыг 2024 онтой харьцуулахад 27.5 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна
- ✓ Төсвийн урсгал зардалд үндэслэх тооцоо судалгаагүйгээр 838.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна
- ✓ Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд тусгагдсан нийт хөрөнгө оруулалтын ТАХ-ний 44.4 хувь нь төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.
- ✓ Нийт хөрөнгө оруулалтын ТАХ-ний 33.3 хувь нь аймгийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалтын саналд хуулиар хориглосон ажлыг тусгаж төлөвлөөгүй байна
- ✓ Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй хэрэгжилт 88.9 хувьтай байна.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ АЙМАГ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

Аудитаар нийт 5,593.6 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнд 5 албан шаардлага хүргүүлээ.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

-----o0o-----



## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



## БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/145

Эрдэнэбулган сум

#### Гүйцэтгэллийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.

3.Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хугацаанд нь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар)-т даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг архивын нэгж болгож, архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Н.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны... дугаар сарын...-ны өдрийн... тушаалын хавсралт

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх"- д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл  
Аудв APA-2024/03/-01-НА-НА

№	Хүргүүлсэн шийдвэрийн		Шийдэрийн			Хэрэгжилтийг хариуцах	
	Утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Тоо	Дугаар	Шийдэл	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 67 дугаар зүйлийн 67.2 -д заасан төсвийн төслийн танилцуулга мэдээллийг хуульд заасан дарааллын дагуу, иж бүрэн байдлаар бэлтгээгүй байна		1	443	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга	Б Цэрэннадмид
2	Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг гэж заасны дагуу торгуулийн орлогын 40 хувь буюу 480.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн боловч хэрэгжүүлэх арга, хэмжээ тодорхойгүй, тооцоо судалгаагүй байна.	480.00	1	444	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга	Б Цэрэннадмид
3	Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд Засаг даргын ерөнхий дансанд хотын нийтийн хүн тээвэр үйлчилгээнд үндэслэх тооцоо судалгаагүй, нотлох баримтгүйгээр 358.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байх бөгөөд тухайн санхүүжилтийг олгох, тайлагнах, хяналт тавих нарийвчилсан журамгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.	358.1	1	445	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга	Б Цэрэннадмид
4	Ажлын даалгавар, ТЭЗҮ зураг төсөв эцэслэн боловсруулаагүй орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3,655.5 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,100.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ, нийт 4,755.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 16 төсөл арга хэмжээг орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд тусгасан байна.	4,755.50	1	446	Албан шаардлага	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	А Батболд
5	Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаагүй 24 төсөл арга хэмжээг орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	-	1	447	Албан шаардлага	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	А Батболд
<b>НИЙТ ДҮН</b>		<b>5,593.60</b>	<b>5</b>				



## Хавсралт 1

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний дэлгэрэнгүй жагсаалт (сая төгрөг)

Д/д	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх/дуусах хугацаа	Төсөвт өртөг	Санхүүжүүлэх дүн	Ангилал
1	ОНТХО	Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засвар	2025-2025	87.37	87.37	Их засвар
2		Цэцэрлэг сумын ЕБС-ийн их засвар	2025-2026	700.00	450.00	Их засвар
3		11 дүгээр цэцэрлэгийн их засвар Эрдэнэбулган сум	2025-2025	650.00	650.00	Их засвар
4		Жаргалант сумын 75 дотуур байрны их засвар	2025-2025	275.59	275.59	Их засвар
5		Өндөр-Улаан сумын 80 ортой дотуур байрны их засвар	2025-2026	335.29	232.57	Их засвар
6		Эрдэнэмандал сумын Сургуулийн их засвар	2025-2026	580.00	400.00	Их засвар
7		Хайрхан сумын Соёлын төвийн их засвар	2025-2025	320.00	320.00	Их засвар
8		Хотонт сумын Сургуулийн их засвар	2025-2025	540.00	540.00	Их засвар
9		Чулуут сумын Цэцэрлэгийн их засвар	2025-2025	150.00	150.00	Их засвар
10		Хүүхдийн номын сан, төв номын сангийн их засвар	2025-2025	250.00	250.00	Их засвар
11		Нийтийн эзэмшлийн талбайн засвар тохижилт	2025-2025	300.00	300.00	Их засвар
12	ОНХСан	Хүүхдийн тамир зуслангийн засвар тохижилт 2025 онд ариун цэврийн байгууламж	2025-2025	450.0	450.0	Их засвар
13		Хархираа голын гүүр Өлзийт сум	2025-2025	150.0	150.0	Зам гүүр
14		Аялал жуулчлал, авто замын тэмдэг, тэмдэглэгээ	2025-2025	200.0	200.0	Ажлын даалгавар
15		Булган сумын төвийн дэд бүтцийн зураг төсөв	2025-2025	150.0	150.0	Зураг төсөв
16		Чулуутын голд бирвааз гүүр Цэцэрлэг сум	2025-2025	150.0	150.0	Зам гүүр
<b>Нийт дүн</b>				5,288.3	4,755.5	